

## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

### LEGAL REFORM ON COMBATING DOMESTIC VIOLENCE



**Д.Саруул.** Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн  
**Saruul.D.** An officer of Legal Reform Department, Ministry of Justice

**Abstract:** Although, Mongolia adopted “Combating domestic violence Code” in 2004, the implementation of the current Law is not sufficient in practice. Therefore, regulations on preventing human rights violation within family, supporting safety, and investigating violence at early stage, settling, supporting and providing necessary services to victims shall be reformed in complex. In this report, characteristic of legal reform on domestic violence and coherence of this regulation with Criminal Justice reform.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй”, 16 дугаар зүйлд иргэн “...аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”, “Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална” хэмээн заасан билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх, үүний дотор хохирогчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох заалт тусгагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д “Гэр бүлийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэгт “цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах”- арга хэмжээ

авахыг тус тус заасан байна.

Иймд гэр бүл дэх аюулгүй байдлын асуудлыг Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цогцоор авч үзэж, уялдуулан зохицуулах нь чухал байна.

**Практик үндэслэл, шаардлага:** Монгол Улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталснаас хойш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр<sup>4</sup>, Улсын Дээд шүүхээс тус хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх тухай тайлбар<sup>5</sup>, ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ-аас хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмуудыг<sup>6</sup> батлан хэрэгжүүлж байна.

Мөн төрөөс хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалан байрлуулах, гэр бүлд утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг гэрээгээр мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан, үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг

<sup>4</sup> Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоол

<sup>5</sup> Улсын дээд шүүхийн 2006 оны 47 дугаар тогтоол

<sup>6</sup> “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он “Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох” заавар 2009 он “Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлөн эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах заавар. ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он

<sup>7</sup> “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам”. ЭМ, ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009 он.

бодлого, үйл ажиллагааны хүрээнд нааштай алхмууд хийгджээ.

Гэвч хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болжээ. Тухайлбал, сүүлийн 3 жил 8 сарын хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 1505 бүртгэгдсэнээс улмаас 49 хүн амь насаа алдаж, 1180 хүн гэмтсэн байна.<sup>8</sup> Үүний гол шалтгааныг хуулийн зохицуулалт оновчтой бус, ялангуяа байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий, салангид байдлаар тусгаж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах процедурыг орхигдуулсантай холбоотойг хууль хэрэгжүүлэгч мэргэжилтнүүд, энэ чиглэлээр ажилладаг байгууллага, судлаачид анхааруулсаар байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй болон захиргааны зөрчид тооцогдон арга хэмжээ авагдсан хүчирхийллийн тоо үүнээс даруй 5 дахин их байгааг энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудын судалгаа харуулж байна.<sup>9</sup>

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 8 жил гаран хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах 41 шийдвэрийг шүүх гаргасан ч тэдгээр шийдвэрүүдийн нэг нь ч хэрэгжээгүй байна.<sup>10</sup>

Хэрэгжилтийн үр дүнгүй байдал нь хуулийн зохицуулалт оновчтой бус, ялангуяа байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий, салангид байдлаар тусгаж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах процедурыг орхигдуулсантай холбоотой байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар гэр бүлийн хүчирхийллийн ноцтой хэлбэрийг гэмт хэрэгт тооцдог ч дийлэнх хэсгийн зөрчил хэмээн үзэж нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн танхайрах, согтуурахтай холбоотой зүйлд заасны дагуу эрүүлжүүлэх, 15.000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 30 хүртэл хоног баривлах арга хэмжээ авч, хохирогчийн давхар хохироож байна.

Харин хохирогч хүсвэл хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлуулах арга хэмжээг авахуулах хүсэлтийг шүүхэд иргэний журмаар гарган шийдвэрлүүлэх боломжийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан ч энэ нь гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хохирогчийн үүрэг болгож, эрсдэлд оруулахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахад хүргэж байна.

Хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль/2002 он/, Захиргааны хариуцлагын тухай/1992 он/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай/2004 он/, Хүүхдийн эрхнийг хамгаалах тухай/1996 он/, Гэр бүлийн тухай/1999 он/ зэрэг

<sup>8</sup> Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ. 2010-2013 оны 8 сарын байдлаар.

<sup>9</sup> ХЭҮТ-ийн судалгаа. 2010 он.

<sup>10</sup> Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан. ННФ, ХЭҮТ. 2010 он.

хуульд хуульчилсан хэдий ч ямар тохиолдолд хүлээлгэх үндэслэл тодорхойгүй, давхардсан, өөрөөр хэлбэл адил үйлдэл, эс үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг ялгаатай байдлаар тодорхойлсон нь гэм буруутай этгээдэд ял завших, хуулийн хариуцлагаас сугарч үлдэх боломж олгож байна.

Тухайлбал, хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн хүнд хүлээлгэх хариуцлагыг дараах байдлаар давхардуулан хуульчилсан байна:

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд 40000-50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд 1 жил хүртэл хугацаагаар хүүхэдтэйгээ уулзах эрхийг нь хязгаарлах;
- Эрүүгийн хуулийн 100-р зүйл буюу тарчлаасан хэмээн үзэж 3-6 сарын хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар хорих;
- Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан бол эцэг, эх байх эрхийг хасах.

Хэдийгээр Гэр бүлийн тухай хуульд заасан эрх хязгаарлах арга хэмжээ болон Гэр бүлийн тухай хуульд заасан эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах арга хэмжээг тухайн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэрэг, эсхүл зөрчил байхаас үл хамааран давхардуулан ногдуулж болох ч практикт хэвшин тогтоогүй, энэ төрлийн хариуцлага хүлээлгэсэн ч хэрэгжүүлэх процесс байхгүйгээс үр дүнгүй болдог байна.

2004 онд хуулийг батлахдаа дагалдах хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулаагүйгээс хууль хоорондын хийдэл, зөрчилдөөнт байдал үүссэнээс гадна хохирогчийн аюулгүй байдалтай холбоотой хамгаалалт огт зохицуулалтгүй үлдэхэд хүрчээ. Хэдийгээр Засгийн газар, яам, агентлагаас гаргасан эрх зүйн актаар хуулийн дээрх хийдлийг нөхөх оролдлого хийж байгаа ч хамрах хүрээ, хууль зүйн хүчин чадлынхаа хувьд салбар хоорондын зохицуулалтыг хангаж чадахгүй байна.

Энэ бүгд нь хуулийн зохицуулалтыг хүчгүй, тунхаглалын шинжтэй болгохын зэрэгцээ хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд төвөгтэй байдлыг үүсгэн хохирогчийг дахин хүчирхийлэлд өртөх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлагаас мултрах боломжийг олгож байна. Тухайлбал, Нийслэлийн хэмжээнд хуулийн байгууллагад ажиллаж байгаа нийт 400 хуульчдаас авсан асуулгын судалгаагаар тэдний дөнгөж 10% нь тус хуулийг хэрэглэж үзсэн хэмээн хариулсан байна.

<sup>11</sup> Иймд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэн шинэтгэх

<sup>11</sup> НҮБ-ын ХАС, ХЭХ-ны хамтарсан судалгаа. 2010 он

нь чухал байна.

Энэ үүднээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэн шинэтгэх шаардлагын дагуу Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Төсөл боловсруулахад 2013 онд АНУ-ын Миннесота мужийн “Хүний Эрхийн Өмгөөлөгчид” байгууллага (Minnesota Advocates for Human Rights), Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн мониторинг болон Хууль зүйн үндэсний хүрээлэн, УДШ-ийн судалгааны төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагаас 2005 -2013 оны хооронд хийгдсэн 20 гаруй дүн шинжилгээ, судалгааны материалыг ашигласан байна.

Дээрх судалгаанаас гадна НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сангаас болон Conrad N.Hilton Сан, Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ба хөгжил Сангаас тус тус боловсруулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль, АНУ, Канад, Албани, Япон, Өмнөд Африк, Вьетнам, Тайвань зэрэг улсуудын хууль, НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Зөвлөмжүүдийг боловсруулалтын ажилд ашигласан болно.

### Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын өөрчлөлтүүдийг тусгасан болно.

1 бүлэг	•Нийтлэг үндэслэл
2 бүлэг	•Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо
3 бүлэг	•Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ
4 бүлэг	•Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах
5 бүлэг	•Хохирогчид үзүүлэх үйлчилгээ
6 бүлэг	•Бусад зүйл

Хуулийн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлоход чиглэгдэж байгааг өөрчилж,

хохирогч, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтыг шинээр нэмж томъёолно.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл **6 бүлэг 42 зүйлтэй.**

**Хуулийн зорилтыг** гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох хэмээн **өргөжүүлэн томъёолж,**

- хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах;
- хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах;
- хохирогчийн аюулгүй байдлыг шуурхай хамгаалах;
- нууцлалыг хадгалах;
- салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах зарчмыг тогтоосон.

Эдгээр зарчимтай уялдуулан дараах багц өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа:

1. Хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөж гэрлэгчид, хамтран амьдарч, гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамгаалуулагч, харгалзан дэмжигч, дэмжүүлэгч, тодорхой нөхцөл шалтгааны улмаас тухайн гэр бүлд амьдарч байгаа хүн, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд, төрсөн болон үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүүгээс гадна эхнэр, нөхөр байсан, дундаасаа хүүхэдтэй хүмүүсийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулсан. Энэ нь хохирогчдын дийлэнх хэсэг хуулийн хамгаалалтын гадна үлдэж байсныг өөрчилж, хамгаалалтад хамрагдах боломжтой болж байна.

2. Гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн зөрчлийн хэмжээнд авч үзэж байсныг өөрчилж гэмт хэрэгт тооцон, ял ногдуулах зохицуулалтыг томъёолсон. Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцсноор гэм буруутай этгээдэд хариуцлага гарцаагүй хүлээх нөхцлийг бүрдүүлсэн. Мөн гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцоноор хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай<sup>12</sup>, Тахарын албаны тухай хуульд<sup>13</sup> заасан хамгаалалтыг давхар авах боломж бүрдэх болно.

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа салангид, зарим яамны чиг үүрэг орхигдсон байгааг өөрчилж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбар дундын асуудлыг Хууль зүйн сайдаар ахлуулсан Дэд зөвлөл хариуцахаар, мөн Боловсрол, Соёлын болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яамдын чиг үүргийг илүү нарийвчлан тодорхойлж, харъяа мэргэжилтнийг сургах, мэргэшүүлэх үүргийг холбогдох байгууллагуудад даалгасан.

<sup>12</sup> Тус хууль нь 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан.

<sup>13</sup> Тус хууль нь 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан.

4. Гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх суваг хязгаарлагдмал байдлаар хуульчлагдсан байсныг өөрчилсөн мэдээлэх үүрэг бүхий этгээдэд:

- бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтан;
- эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан;
- баг, хороо, сум, дүүргийн холбогдох албан тушаалтан;
- төрийн алба хаагч болон төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж

байгаа төрийн бус байгууллагын мэргэжилтэнг хамруулан өргөжүүлсэн.

Мөн мэдээлэгчийн талаарх нууцлалыг хадгалах, шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах зохицуулалтыг тусгасан.

5. Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалт тухнаглалын шинжтэй, хэрэгжүүлэх процесс тодорхойгүй хуульчлагдсаныг өөрчилж, хохирогчийг богино хугацаанд хамгаалалтаар хангах боломжийг нэмэгдүүлэхэд анхаарч цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг даргын хүлээх үүргийг тодруулж, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор орон байранд нэвтрэн орох, баривчлах, галт зэвсэг болон зэвсгийн чанартай зүйлсийг хураах зэрэг ажиллагаа явуулах цагдаагийн алба хаагчийн эрх хэмжээг Хууль сахиулах тухай хуулийн төсөлд,<sup>14</sup> тусгуулах үндэслэлийг хамруулсан.

6. Хохирогчид үзүүлэх үйлчилгээ цогц бус, төрөлжөөгүй, салангид байдлаар хуульчлагдсан, хэн, ямар журмаар үзүүлэх талаарх зохицуулалт тодорхойгүй байсныг өөрчилсөн. Хохирогчид үзүүлэх үйлчилгээ

- аюулгүй байдлын хамгаалалт;
- эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
- сэтгэл зүйн үйлчилгээ;
- нийгмийн халамжийн үйлчилгээ;
- хүүхэд хамгааллын үйлчилгээ;
- хууль зүйн туслалцаа гэсэн төрөлтэй байхаар томъёолж,

хэрэгжүүлэгч субъект, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мөн үйлчилгээг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх талаарх зохицуулалтуудыг тусгасан.

7. Хүүхдийн онцлог, хэрэгцээг харгалзсан хамгаалалт, үзүүлэх үйлчилгээг нэгтгэх зорилгоор “Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах” гэсэн тусгай бүлгийн зохицуулалтыг нэмж томъёолсон. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх үүргийг мэргэжилтнүүдээс гадна иргэдэд хүлээлгэсэн.

8. Хуулийн хэрэгжилтэд тавих шаталсан хяналтыг олон нийтийн хяналттай хосолсон байдлаар тусгасан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар Улсын Их хурал Засгийн газрын үйл ажиллагаанд, Засгийн газар

<sup>14</sup> Тус хуулийн төслийг Хууль зүйн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг боловсруулж байна.

гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд, Дэд зөвлөл яамд болон орон нутгийн Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд, Салбар зөвлөл баг, хороо, сумын түвшинд ажиллах мэргэжилтнүүдээс бүрдсэн хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг тусгалаа.

### **Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар:**

Хуулийн төсөл батлагдснаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах төрийн бүтэц, механизм, байгууллага, албан тушаалтнуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог нарийвчлан зохицуулахтай холбогдсон эрх зүйн орчин бүрдэнэ.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичиг, мөн Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах хууль,<sup>15</sup> одоо боловсруулагдаж байгаа Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай болон Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслүүдтэй тус тус уялдуулсан.

Мөн уг хуулийн төслийг боловсруулж батлуулахтай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан болно.

<sup>15</sup> Тус хууль нь 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан.